



*ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу Хэнтий аймгийн Аудитын
газрын 2016 онд хийсэн нийцлийн аудит*

**САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ
ЗАРЦУУЛСАН БОЛОВЧ ДОТООД ХЯНАЛТЫГ
ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

Аудитын код: **ҮАГ-НАГ/2016/03-НА-ХЭ**

Аудитын нэр: “Засгийн газрын тусгай сангийн үйл
ажиллагааны үр дүн” /Мэргэжлийн
боловсрол, сургалтыг дэмжих сан/

Чингис хот

2016 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
НА	Нийцлийн аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Тайлан бэлтэгсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн аудитын газар Хэнтий аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Ахлах аудитор: Н.Туяа Аудитор: Ц.Хатанболд 2016 оны 10 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу Хаяг: Хэнтий аймаг, Чингис хот, АЗДТГ- ын байр 325 тоот өрөө	АГУУЛГА	
	Ерөнхий зүйл	4
	Нэг. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.	5
	Хоёр. МСҮТ-д МБСДС-ийн төлөвлөлт хийгддэггүй байна.	5
	Гурав. Сангийн хөрөнгийн зориулалтын дагуу зарцуулсан боловч үр дүнг үнэлэх ажил хийгддэггүй байна.	5
	Дөрөв. МБСДС-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.	5-7
	Дөрөв. Дүгнэлт	8
	Тав. Аудитын зөвлөмж	8
	Зургаа. Холбогдох байгууллагын санал	9
	Долоо. Хавсралтууд	10-18

Ерөнхий зүйл

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.4 заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд Хэнтий аймгийн Аудитын газар гүйцэтгэлийн аудит хийв.

2. Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган, МСҮТ-ийн захирал нарт аудитын дүнг танилцуулж, ҮАГ-т аудитын тайланг хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- *Хууль эрх зүйн зохицуулалт оновчтой байна уу?*
- *Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байна уу?*
- *Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулж үр дүн гарч байна уу?*
- *Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх*
- *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт*

Аудитад Хэнтий аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Бор-Өндөр сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн 2015, 2016 оны энхий хагас жилд МБСДС-аас олгосон хөрөнгийн зарцуулалтыг дансны хуулга болон анхан шатны баримтуудыг үндэслэн шалгалаа.

Аудитыг АДБООУС 100-400, 4200, нийцлийн аудитын гарын авлагыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авч, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллалаа.

3. Шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны талаархи товч мэдээлэл

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 21-26 дугаар зүйлийг үндэслэн 2010 онд Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан байгуулагдаж ЗГ-ын 2011 оны 117 тоот тогтоолоор “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд заасны дагуу энэ сангийн санхүүгийн удирдлагын үүргийг Хөдөлмөрийн сайд эрхлэх бөгөөд сангийн хөрөнгийн зарцуулалтанд боловсрол, санхүү, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл хяналт тавьж ажиллаж байна.

Давхардсан тоогоор 2 МСҮТ-ийн 7885 сурагчийн 492,4 сая төгрөгийн тэтгэлэгийн материалыг үзэж шалгалаа. МСҮТ-ийн анги удирдсан багш ангийн ирцийн нэгтгэлийг гаргаж, сургалтын алба, нягтлан бодогч, захирлаар хянуулан ирцийн хувьд ноогдуулан тэтгэмжийг олгож ажилласан байна.

**НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ**

- **Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.**

1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.1 Боловсролын тухай хуулийн 40.6 “...мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, зээл, тэтгэлгийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно”, 43.2.10 “мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу сар тутам тэтгэлэг олгох”, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 21-25 дугаар зүйлд сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг тодорхойлсон байна. Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль болон “Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлагдсан байна.

Засгийн газрын 2013 оны 329 дүгээр тогтоолоор Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад хичээлийн жилд сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 70.000.0 (далан мянган) төгрөгөөр тогтоосон байна.

1.2 ЗГ-ын 2015 оны 477 тоот тогтоолоор батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журмаар тэтгэлэг олгох үндэслэл, тэтгэлэг олгох нөхцөл, санхүүжилт зэргийг зохицуулсан байна.

1.3 Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль болон мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам нь бусад хууль тогтоомжтой нийцэж байна.

**ХОЁРДУГААР
БҮЛЭГ**

- **Төлөвлөлтийн ажил орон нутагт хийгддэггүй байна.**

2. МБСДС-ийн сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол сургалтын асуудал хариуцсан төв байгууллага хэрэгжүүлдэг байна.

2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр заагдсан тул орон нутагт төлөвлөлтийн ажил хийгддэггүй байна.

2.2 Хамаарахгүй

**ГУРАВДУГААР
БҮЛЭГ**

- **Сангийн үр дүнг үнэлдэггүй байна.**

3. Сангийн хөрөнгийн зориулалтын дагуу зарцуулсан боловч үр дүнг үнэлсэн дүгнэсэн мэдээлэл байхгүй байна.

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2. “өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид

ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг” заалт болон ЗГ-ын газрын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан журамтай тэтгэлэг олгох үйл ажиллагаа нь нийцэж байна.

- 3.1.1 Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 2015 онд Хэнтий аймгийн МСҮТ-д 141,2 сая төгрөгийн тэтгэлэг, Бор-Өндөр сумын МСҮТ-д 60,9 сая төгрөгийн тэтгэлэг, 10,0 сая төгрөгийн E-TVET мэдээллийн систем худалдан авах зардлуудыг тус тус санхүүжүүлсэн нь журмын 1.2 дахь заалттай нийцэж байна.

3.2 Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

- 3.2.1 Бор-Өндөр сумын МСҮТөвд 14,5 сая төгрөгийн e-TVET мэдээллийн системийг худалдан авахдаа шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн харьцуулалтын арга ашиглаж тендер шалгаруулалт зохион байгуулах гэснийг зөрчиж байна.

3.3 Гэрээг хугцаандаа хэрэгжүүлээгүйг эс тооцвол бусад шаардлагыг хангаж байна.

- 3.3.1 Бор-Өндөр сумын МСҮТөвд 14,5 сая төгрөгийн e-TVET мэдээллийн системийг Кареер март ХХК-аас худалдан авч гэрээний эхний төлбөр буюу 10,0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэрээний хавсралт болох "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад сургалт удирдлагын E-TVET мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө"-ний дагуу 2016 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр буюу гэрээний хугацаанаас 33 хоногийн дараа захиалагч талд бүрэн хүлээлгэж өгсөн байна.

3.4 МБСДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн зорилтот үр дүн тодорхой бус байна.

Сангийн хөрөнгөөр Хэнтий МСҮТ-д 2015 онд 141,2 сая, 2016 онд 124,3 сая төгрөг нийт 265,5 сая төгрөгийн тэтгэлэг олгогдсон байна.

Бор-Өндөр МСҮТ 2015 онд 60,9 сая, 2016 онд 58,9 сая төгрөг нийт 119,8 сая төгрөгийн тэтгэлэг олгогдож, 10,0 сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.

МСҮТ-үүдийн 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар тусгаагүй байна

- 3.4.1 Хэнтий МСҮТ-д 2015 оны 1 дүгээр улиралын тэтгэлэгээс 2 сурагчийн тэтгэлэг болох 296,6 мянган төгрөг, нэр бүхий 10 сурагчдаас 70,0 мянган төгрөг нийт 366,6 мянган төгрөгийг анги удирдсан багш Д.Батхуягын харилцах дансанд шилжүүлсэн байна.
- 3.4.2 Бор-Өндөр сумын МСҮТөвийн багш С.Анхтуяагын дансанд сурагчдын тэтгэлэгээс 470,0 мянган төгрөг шилжүүлсэн байна.
- 3.4.3 Бор-Өндөр МСҮТ-д 4 сурагчийг элсэлтээр авсан нь тушаалаар баталгаажуулагдаагүй байхад 373,3 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

**ДӨРӨВДҮГЭЭР
БҮЛЭГ**

- Дотоод хяналт хангалтгүй байна.

4. Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.

- 4.1 Сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина гэж заасан байна. МУ-ын ЗГ-ын 2011 оны 117 дугаар тогтоолоор батлагдсан Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын 4.3-д Журмын хэрэгжилтэд Үндэсний зөвлөл, боловсрол, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина гэж тусгасан байна.

4.1.1 Бор-Өндөр сумын МСҮТ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.3.2-д сургуулийн төсвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах гэсэн заалтыг оруулсан байна.

4.1.2 Хэнтий аймгийн МСҮТ-ийн 2015 он, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт шалгалт хийхээр тусгасан байна.

4.2 Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

4.2.1 Бор-Өндөр МСҮТ-ийн дотоод хяналтаар "Нягтлан бодогч нь суралцагч нарын тэтгэлэг бодохдоо журналын ирцтэй тулгаж үзэхгүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 477 дугаар тогтоолыг зөрчиж байна" гэсэн дүгнэлт хийсэн боловч хэдий хэмжээний зөрчил илэрсэн талаар мэдээлэл байхгүй байна.

4.2.2 Хэнтий МСҮТ-ийн 2015 он, 2016 оны дотоод хяналтын тайлан гаргасан боловч сангийн үйл ажиллагааг хамруулаагүй байна.

4.2.3 Хөдөлмөрийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Хэнтий аймгийн Бор-Өндөр МСҮТ-ийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн хадгалалт хамгаалалт гэсэн дотоод аудит хийсэн байна. Уг тайланд "... төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт зохих түвшинд хэрэгжихгүй байгаагийн улмаас төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим зөрчигдөж, ...хяналт хангалтгүй байна" гэж дүгнэсэн байна. Мөн Хэнтий МСҮТ-д хийсэн шалгалтын тайландаа "... Оюутаны тэтгэлгийг олгохдоо хичээлийн ирцийн бүртгэлийг үндэслэн хувиар тооцож олгосон байна. Тэтгэлэг олголтын баримтыг статистик тоо, ангийн журнал, бичиг баримттай тулгалт хийж үзэхэд зөрүүгүй байлаа" гэж тусгасан байна.

4.3 Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

4.3.1 Бор-Өндөр МСҮТ-д 14,5 сая төгрөгийн e-TVET мэдээллийн системийг "Кареев март" ХХК-иас худалдан авч гэрээний эхний төлбөр буюу 10,0 сая төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдөр шилжүүлсэн боловч Шилэн дансны тухай хуулийн 6.10-д заасан ашиг сонирхолын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй, 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн системд байршуулаагүй байна.

Дөрөв. ДҮГНЭЛТ

1. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
2. Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
3. Дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.
4. Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна

Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

МСҮТ-ийн захирал нарт:

1. Сургалтын явцад чөлөөлөгдсөн, нэмэлт элсэлтээр суралцах сурагчдын нэрсийг тушаал шийдвэрээр бүрэн албажуулж байх.
2. Худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дах заалтын дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа босго үнийг үндэслэн тендер шалгаруулалтыг зохион байгуулж байх
3. Дотоод хяналтаар сурагчдын ирцийг улирал бүр шалгаж байх, дотоод хяналтаар илэрсэн асуудлыг залруулах арга хэмжээ авч ажиллах
4. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заагдсан хугацаанд бүрэн оруулж, түүнд тавих хяналтыг сайжруулах

Зургаа. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг хавсралт 9 маягтаар гарган 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдөр МСҮТ-үүдэд хүргүүлсэн болно. Хэнтий МСҮТ 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 163 тоот албан бичгээр "...асуудлын бүртгэлтэй холбоотой санал хүсэл байхгүй" гэсэн, Бор-Өндөр МСҮТ-ээс албан бичгээр хариу ирээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Долоо. ХАВСРАЛТУУД

1. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийн хүснэгт
2. МБСДС Нэгтгэлийн маягт судалгаа
3. Асуудлын бүртгэл
4. Тайлан баталгаажуулсан тушаал

Тайлан бичсэн: Аудитор

Ц.ХАТАНБОЛД

Огноо: 2016.10.13

Аудитын зөрчлийн нэгтгэлийн хүснэгт /мян.төг/

дд	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа зөрчил				Нийт дүн
		Залруул аг даагүй	Акт	Албан шаардл ага	Зөв-лөмж	
1	Хэнтий МСҮТ-д 2015 оны 1 дүгээр улиралын тэтгэлэгээс 2 сурагчийн тэтгэлэг болох 296,6 мянган төгрөг, нэр бүхий 10 сурагчдаас 70,0 мянган төгрөг нийт 366,6 мянган төгрөгийг анги удирдсан багш Д.Батхуягын харилцах дансанд шилжүүлсэн байна.	366,60				366,60
2	Бор-Өндөр сумын МСҮТөвийн багш С.Анхтуяагын дансанд сурагчдын тэтгэлэгээс 470,0 мянган төгрөг шилжүүлсэн байна.		470,00			470,00
3	Бор-Өндөр МСҮТ-д 4 сурагчийг элсэлтээр авсан нь тушаалаар баталгаажуулагдаагүй байхад 373,3 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.	373,30				373,30
4	Шилэн дансны тухай хуулийн 6.10, 6.4.4, 6.4.5 мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд байршуулаагүй байна.					
5	Бор-Өндөр сумын МСҮТөвд 14,5 сая төгрөгийн e-TVET мэдээллийн системийг худалдан авахдаа шууд гэрээ байгуулсан				10 000,00	10 000,00
	Дүн	739,90	470,00	-	10 000,00	11 209,90